

“Монгол-Германы Чуулган”-ы дэргэдэх оюутан, залуусын “АЛТАН АРГАМЖ” клубын товч танилцуулга

ХБНГУ нь Монгол Улсын хувьд Европ дахь хамгийн гол түнш орон бөгөөд манай улсад герман хэлийг сонирхдог болон суралцдаг 30 орчим мянган хүн байдаг ба энэ тоо цаашид ч өсөх хандлагатай байна. Одоогийн байдлаар 10 гаруй их, дээд сургуулиудад герман хэлний мэргэжилтэн бэлтгэж, мөн тооны их, дээд сургуулиудад олон залуус герман хэлийг сонгон суралцаж, 30 гаруй сургалтын төвүүд герман хэлний сургалт явуулж байна.

Монгол-Германы хамтарсан болон дагнасан олон байгууллага, сангууд идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг бөгөөд жишээлбэл Монгол Германы Чуулган, Монгол Германы Нийгэмлэг, Монгол Германы Бизнесийн зөвлөл, Германд төгсөгчдийн “Гүүр” клуб, Герман Хэл Сонирхогчдийн Нийгэмлэг, Гёте болон 38-р дунд сургуулиуд байдаг билээ. Харин эндээс харахад оюутан бидэнд чиглэсэн тогтмол үйл ажиллагаа явуулдаг байгууллага байгаагүй гэхэд хилсдэхгүй бизээ.

Энэ бүхнийг үндэслээд герман хэлний сургалттай дөрвөн их, дээд сургуулын хэсэг оюутнууд нэгдэн “Монгол-Германы Чуулган”-ы дэмжлэгээр 2003 оны XI сарын 22-ний өдөр оюутан, залуусын “АЛТАН АРГАМЖ” клубыг герман хэлийг сонирхдог, суралцдаг залуусын мэдлэг чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулах, герман хэлийг эзэмшиж буй нийт оюутан, залуучуудыг нэгтгэх, Герман орны түүх, соёлыг олон нийтэд сурталчлах үйлсэд тэдний хувь нэмрээ оруулах эрмэлзлэлийг гүйцэлдүүлэх зорилго тавин үүсгэн байгуулсан юм.

Оюутан, залуусын “АЛТАН АРГАМЖ” клуб нь түүний зорилго, үйл ажиллагааг дэмждэг, Герман орны хэл, түүх, соёлыг сонирхдог, судалдаг, суралцдаг залуус бү, зорилго хэнд гишүүнчлэл нээлттэй байна.

Иймээс та бүхнийг бидэнтэй итгэл, оюунаараа нэгдэнэ гэдэгт найдаж байна.

Клубын эрх барих дээд байгууллага нь бүх гишүүдийн хурал байх бөгөөд Удирдах Зөвлөлийн 7 гишүүнийг тус хурлаас сонгоно. Удирдах Зөвлөлийн гишүүд нь албадыг хариуцна.

“АЛТАН АРГАМЖ” клубын үндсэн гишүүд:

1. Н. Солонго /Отгонтэнгэр Их Сургууль, Герман хэлний багш-орчуулагчийн III дамжаа/
2. Г. Уянга /ХБНГУ-ын Ханновер хотын Анагаах Ухааны Дээд Сургуулийн III дамжаа/
3. Ц. Уянга /МУИС-ОУХС-ийн ОУХ ангийн герман хэлний II дамжаа/
4. Г. Батбуян /Отгонтэнгэр Их Сургууль, Санхүү - I/
5. Б. Ундрал /Соёл Эрдэм Дээд Сургууль, Япон – I/
6. Батболор /Отгонтэнгэр Их Сургууль, Санхүү - I/
7. Г. Батбаяр /Хүмүүнлэгийн Ухааны Их Сургууль, Аялал жуулчлал-франц хэлний III дамжаа/
8. Б. Энхчимэг /Отгонтэнгэр Их Сургууль, Герман хэлний багш-орчуулагчийн IV дамжаа/
9. Э. Эрхэмболд /МУИС, Түрэг судлалын I дамжаа/

Клубын зохион байгуулалт



**“Монгол-Германы Чуулган”-ны дэргэдэх оюутан, залуусын
“АЛТАН АРГАМЖ” клубын дүрэм**

Нэгдүгээр бүлэг

Нийтлэг үндэслэл

1-р зүйл: Дүрмийн зорилт:

1. 1. Энэхүү дүрмийн зорилт нь “Алтан аргамж” клубын зорилго, үйл ажиллагааны чиглэл, бүтэц, удирдлагын зохион байгуулалт, гишүүдийн эрх үүргийг харилцан зохицуулахад оршино.

1. 2. “Алтан аргамж” клуб нь герман хэлийг сонирхдог, суралцдаг оюутан, залуусыг эгнээндээ нэгтгэсэн, гишүүнчлэлгүй клуб байна.

Хоёрдугаар бүлэг

Клубын зорилго, үйл ажиллагааны чиглэл

2-р зүйл: Клубын эрхэм зорилго

2. 1. Герман хэл сонирхдог, суралцдаг оюутан, залуусын эв санааг нэгтгэх, тэдний оюунлаг нөөцөд тулгуурлан Монгол-Германы найрамдалт харилцааг өргөжүүлэн тэлэхэд оюутан, залуусын идэвхтэй оролцоог өрнүүлэхэд бидний эрхэм зорилго оршмой.

3-р зүйл: Үйл ажиллагааны үндсэн чиглэл

3. 1. Герман хэл сонирхон суралцагчдын дунд олимпиад, уралдаан, тэмцээн зохион явуулах

3. 2. Үйл ажиллагааны зорилгод нийцсэн төсөл боловсруулах, хэрэгжүүлэх

3. 3. Үйл ажиллагааны зорилго нэгтэй, төрийн болон төрийн бус байгууллага, холбоо, клубуудтэй хамтран ажиллах

3. 4. Эрдэм шинжилгээ судалгааны ажлыг зохион явуулах

3. 5. Герман хэлээр мэтгэлцээн, хэлэлцүүлэг явуулах

3. 6. Германы үндэсний баяруудыг тэмдэглэн өнгөрүүлэх

3. 7. Герман хэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийсэн хүмүүсийг олонд таниулах үйл ажиллагааг зохион байгуулах, өдөрлөг зохиох гэх мэт.

3. 8. Хуулиар хориглоогүй, дүрэмд нийцэх бусад үйл ажиллагаа

Бүтэц, удирдлагын зохион байгуулалт

4-р зүйл: Клубын бүтэц

4.1. Клуб нь дараах бүтэцтэй байна.

4.1.1. Удирдах зөвлөл

4.1.2. Бусад гишүүд

4.2. Удирдах зөвлөл нь 9 гишүүний бүрэлдэхүүтэй байх бөгөөд клубын Ерөнхийлөгч удирдан зохион байгуулна.

4.3. Удирдах зөвлөлийн гишүүд нь албадын дарга байна.

5-р зүйл: Удирдлагын зохион байгуулалт

5.1. Клубын эрх барих дээд байгууллага нь бүх гишүүдийн хурал мөн.

5.1.1. Бүх гишүүдийн хурал нь 1 жилд 2-оос доошгүй удаа хуралдах бөгөөд Удирдах Зөвлөл зарлаж хуралдуулна.

5.2. Бүх гишүүдийн хурлыг гишүүдийн 2/3-санал гаргасан тохиолдолд зарлан хуралдуулж болно.

5.3. Бүх гишүүдийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

5.3.1. Клубын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах

5.3.2. Клубын бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх

5.3.3. Клубын үйл ажиллагаан үр дүнг хэлэлцэх, тайлан мэдээг дүгнэх

5.3.4. Удирдах зөвлөлийн гишүүдийг томилох, чөлөөлөх

5.3.5. Клубын Ерөнхийлөгч, түүний нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх

5.4. Бүх гишүүдийн хуралтай холбогдсон бусад харилцааг тусгай журмаар зохицуулна.

5.5. Бүх гишүүдийн хурлын хэлэлцэх асуудлын хүрээнд ороогүй аливаа асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж болно.

5.6. Бүх гишүүдийн хурал нь шийдвэрээ дийлэнх олонхийн саналаар гаргана.

5.7. Бүх гишүүдийн хурлын чөлөөт цагт клубыг клубын Ерөнхийлөгч болон албадын дарга нар удирдан зохион байгуулна.

6-р зүйл: Удирдах зөвлөлийн бүрэн эрх

- 6.1. Удирдах зөвлөл нь 9 гишүүнээс бүрдэнэ .
- 6.2. Удирдах зөвлөлийг бүх гишүүдийн хурлаар 2 жилийн хугацаатайгаар сонгогдсон Ерөнхийлөгч удирдах бөгөөд Удирдах Зөвлөлийн гишүүд нь клубын албадын дарга нар байна.
- 6.3. Клуб нь дараах албадтай байна.
 - 6.3.1. Санхүү, эдийн засгийн алба
 - 6.3.2. Хууль, эрх зүйн алба
 - 6.3.3. Гадаад харилцааны алба
 - 6.3.4. Зохион байгуулалтын алба
 - 6.3.5. Хэвлэл мэдээлэл, судалгааны алба
- 6.4. Клубын албадын эрх, үүрэг, үйл ажиллагааг тусгай журмаар зохицуулна.
- 6.5. Клуб нь бусад сургуулиуд дээр салбар клубуудтэй байж болно.
- 6.6. Удирдах зөвлөл нь дараах эрхтэй
 - 6.6.1. Үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө гаргах, хэрэгжүүлэх
 - 6.6.2. Төсөл боловсруулах, төслийн үр дүнг хэлэлцэх
 - 6.6.3. Гишүүн элсүүлэхэд авах хураамжийн хэмжээг тогтоох
 - 6.6.4. Бүх гишүүдийн хурлыг товлон зарлах, бэлтгэл, гүйцэтгэл ажлыг зохион байгуулах
 - 6.6.5. Клубын төсөв, санхүүгийн тайлан тэнцлийг батлах түүнд, хяналт тавих
 - 6.6.6. Клубын үйл ажиллагаатай холбоотой бусад асуудал

7-р зүйл: Ерөнхийлөгчийн эрх

- 7.1 . Клубын Ерөнхийлөгч нь клубыг удирдах чадвар бүхий 18 насанд хүрсэн, герман хэлний зохих мэдлэгтэй Монгол Улсын иргэн байна.
- 7.2 . Ерөнхийлөгчийг Бүх гишүүдийн хурлаар 2 жилийн хугацаатайгаар сонгоно.
- 7.3. Ерөнхийлөгч нь дараах эрх үүрэгтэй
 - 7.3.1. Ерөнхийлөгч нь клубээ гадаад, дотоодод төлөөлөх бүрэн эрхтэй.
 - 7.3.2. Клубыг төлөөлөн өөрт ашигтай, сонирхолын зөрчилгүй гэрээ, хэлцэл байгуулах.
 - 7.3.3. Клубын Ерөнхийлөгч нь удирдах зөвлөлийг тэргүүлж, удирдах зөвлөлийн гишүүдийн ажил үүргийн чиг хандлагыг тодорхойлно.
 - 7.3.4. Хэлэлцэж байж тогтох

Дөрөвдүгээр бүлэг

Гишүүдийн эрх үүрэг

8-р зүйл: *Гишүүн, гишүүн элсүүлэх, хасах журам.*

8.1. Уг клубын гишүүнээр герман хэлний зохих мэдлэгтэй, уг дүрмийг хүлээн зөвшөөрсөн этгээд байна.

8.2. Дээрх шаардлагыг хангасан этгээдийг зохион байгуулалтын алба бүртгэж, гишүүний үнэмлэхийг олгоно.

8.3. Клубын гишүүн өөрөө санал гаргасан, клубын үйл ажиллагаанд байнга биечлэн оролцох чадваргүй болсон, гишүүний үүргийг байнга ноцтой зөрчсөн тохиолдолд клубын Ерөнхийлөгч клубээс хасна.

9-р зүйл: *Гишүүд нь дараах эрхтэй*

9.1. Клубын гишүүн нь дүрмээр хориглоогүй үйл ажиллагаа явуулах эрхтэй.

9.2. Бүх гишүүдийн хуралд оролцох, санал оруулах, санал өгөх

9.3. Клубын үйл ажиллагаанд оролцох, үйл ажиллагааны санаа боловсруулах, гаргах

9.4. Өөрийн сонирхсон албанд харъяаалагдах үйл ажиллагаанд идэвхтэй оролцох эрхтэй

10-р зүйл: *Гишүүд нь дараах үүрэгтэй*

10.1.1 Гишүүн нь 1 жил тутамд Удирдах Зөвлөлийн тогтоосон хэмжээний хураамжийг төлөх үүрэгтэй

10.1.2 Бүх гишүүдийн хуралд товлосон хугацаанд хүрэлцэн ирэх

10.1.3. Гишүүний хураамжаа товлосон хугацаанд бүрэн өгөх

10.2.3. Клубээс зохион байгуулж буй ажилд идэвхтэй оролцох

10.2. Гишүүн нь үүргээ зох ёсоор биелүүлээгүй тохиолдолд дараах хариуцлагыг хүлээлгэнэ.

10.2.1. Торгууль (Дараах зөрчилд оногдуулна)

Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хурал тасалсан (1000 төгрөг)

10.2.2. Сануулах (Клубээс хасахаар) хүлээлгэж өгсөн үүргийг биелүүлээгүй бол

10.2.3. Клубээс хасах

10.3. Эдгээр хариуцлагыг Удирдах Зөвлөл оногдуулах бөгөөд хариуцлагыг давхардуулан оногдуулж болохгүй.

10. 4. Энэхүү дүрэм нь Удирдах Зөвлөлөөр хэлэлцүүлснээр хүчин төгөлдөр болно.